



IAF Mandatory Document

ОУИФ Заавал мөрдөх баримт бичиг

**ИТГЭМЖЛЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН
ТОГТОЛЦООНЫ
БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ШИЛЖҮҮЛЭХ
НЬ**

**TRANSFER OF ACCREDITED
CERTIFICATION OF MANAGEMENT
SYSTEMS**

Хэвлэл 2, Хувилбар 2

(IAF MD 02:2023)

Хэвлэсэн огноо: 14.06.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 15.06.2018

Олон Улсын Итгэмжлэлийн Форум (ОУИФ) нь ОУИФ-ын гишүүнээр итгэмжлэгдсэн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын гаргасан үр дүнг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, Итгэмжлэлийн байгууллага (ИБ)-уудын дунд дэлхий хэмжээний харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэгч болон зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн худалдааг хөнгөвчилдөг.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд итгэмжлэлийн хамрах хүрээнд багтсан ажлаа гүйцэтгэх чадамжтайг батлах замаар бизнес болон тэдгээрийн хэрэглэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг. ОУИФ-ын гишүүн ИБ болон тэдгээрийн итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь олон улсын стандарт, тэдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулсан ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг мөрдөх шаардлагатай.

ОУИФ-ын Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн ИБ-уудын итгэмжлэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд итгэлийг бий болгохын тулд ижил түвшний багаас бүрдсэн үнэлгээг тогтмол явуулдаг. ОУИФ-ын ХХЗХ-ийн бүтцийн талаар ОУИФ-ын бодлогын баримт бичиг 3 (IAF PL 3) “ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний бүтэц ба ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний өргөтгөлийн бодлого, журам”-д дэлгэрэнгүй тусгасан. Мөн ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний талаар ОУИФ-ын ХХЗХ-ийн статус баримт бичигт тусгасан.

ОУИФ-ын ХХЗХ-ийн нь дараах таван түвшний бүтэцтэй. Үүнд:
1-р түвшин нь ISO/IEC 17011 стандартыг хэрэгжүүлэгч бүх ИБ-уудад хамаарах заавал мөрдөх шалгуурыг тодорхойлно. 2-р түвшний үйл ажиллагаа болон холбогдох 3-р түвшний норматив баримт бичиг(үүд)-ийн нэгдлийг ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээ гэж нэрлэдэг. 4-р түвшин (хэрэв байгаа бол) болон 5-р түвшний холбогдох норматив баримт бичгийн нэгдлийг ХХЗХ-ийн дэд хамрах хүрээ гэж нэрлэдэг.

The International Accreditation Forum, Inc. (IAF) facilitates trade and supports industry and regulators by operating a worldwide mutual recognition arrangement among Accreditation Bodies (ABs) in order that the results issued by Conformity Assessment Bodies (CABs) accredited by IAF members can be accepted globally.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited CABs are competent to carry out the work they undertake within their scope of accreditation. ABs that are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

ABs that are signatories to the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) are evaluated regularly by an appointed team of peers to provide confidence in the operation of their accreditation programs. The structure of the IAF MLA is detailed in IAF PL 3 - Policies and Procedures on the IAF MLA Structure and for Expansion of the Scope of the IAF MLA. The scope of the IAF MLA is detailed in the IAF MLA Status document.

The IAF MLA is structured in five levels: Level 1 specifies mandatory criteria that apply to all ABs, ISO/IEC 17011. The combination of a Level 2 activity(ies) and the corresponding Level 3 normative document(s) is called the main scope of the MLA, and the combination of Level 4 (if applicable) and Level 5 relevant normative documents is called a sub-scope of the MLA.

- ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалт гэх мэт үйл ажиллагаа болон ISO/IEC 17065 зэрэг холбогдох заавал мөрдөх стандарт багтана. Үндсэн хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил найдвартай гэж үзнэ.
- ХХЗХ-ийн дэд хүрээнд тохирлын үнэлгээний шаардлагууд буюу ISO 9001 болон схемийн тусгай шаардлага, тухайлбал ISO 22003-1 стандартууд багтана. Дэд хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил тэнцүү гэж үзнэ.

ОУИФ-ын ХХЗХ нь тохирлын үнэлгээний үр дүнг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг төрүүлдэг. ОУИФ-ын ХХЗХ-т гарын үсэг зурсан ИБ-аар итгэмжлэгдсэн байгууллагын ОУИФ-ын ХХЗХ-ийн хүрээнд гаргасан баталгааг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, улмаар олон улсын худалдааг хөнгөвчилнө.

Хэвлэл 2, Хувилбар 2

Боловсруулсан: ОУИФ-ын Техникийн хороо

Баталсан: ОУИФ-ын гишүүд

Огноо: 12.06.2017

Хэвлэсэн огноо: 14.06.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 15.06.2018

Холбоо барих: Элва Нилсен

ОУИФ Нарийн бичгийн дарга

Утас: +1 613 454-8159

И-мейл: secretary@iaf.nu

- The main scope of the MLA includes activities e.g. product certification and associated mandated standards e.g. ISO/IEC 17065. The attestations made by CABs at the main scope level are considered to be equally reliable.
- The sub scope of the MLA includes conformity assessment requirements e.g. ISO 9001 and scheme specific requirements, where applicable, e.g. ISO 22003-1. The attestations made by CABs at the sub scope level are considered to be equivalent.

The IAF MLA delivers the confidence needed for market acceptance of conformity assessment outcomes. An attestation issued, within the scope of the IAF MLA, by a body that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide, thereby facilitating international trade.

Issue 2, Version 2

Prepared by: IAF Technical Committee

Approved by: IAF Members

Date: 12 June 2017

Issue Date: 14 June 2023

Application Date: 15 June 2018

Name for Enquiries: Elva Nilsen

IAF Corporate Secretary

Contact Phone: +1 (613) 454 8159

Email: secretary@iaf.nu

АГУУЛГА

- 0. УДИРТГАЛ
- 1. ТОДОРХОЙЛОЛТ
 - 1.1 Баталгаажуулалтыг шилжүүлэх нь
- 2. ХАМГИЙН БАГА ШААРДЛАГА
 - 2.1 Баталгаажуулалтыг шилжүүлэхэд тавих нөхцөл
 - 2.2 Шилжүүлэхээс өмнөх дүн шинжилгээ
 - 2.3 Баталгаажуулалтыг шилжүүлэх нь
 - 2.4 Баталгаажуулалтын Олгогч болон Хүлээн авагч байгууллага хоорондын хамтын ажиллагаа

TABLE OF CONTENTS

- 0. INTRODUCTION
- 1. DEFINITIONS
 - 1.1 Transfer of Certification
- 2. MINIMUM REQUIREMENTS
 - 2.1 Eligibility of a Certification for Transfer
 - 2.2 Pre-Transfer Review
 - 2.3 Transfer of Certification
 - 2.4 Cooperation Between the Issuing and Accepting Certification Bodies

ОУИФ-ЫН ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байвал зохино” нэр томъёо нь шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллагад (ИБ) нотлон харуулсан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байх ёстой” нэр томъёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

INTRODUCTION TO IAF MANDATORY DOCUMENTS

The term “should” is used in this document to indicate recognised means of meeting the requirements of the standard. A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term “shall” is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

**Олон улсын итгэмжлэлийн форум
(ОУИФ)-ын заавал мөрдөх баримт бичиг:
Итгэмжлэгдсэн менежментийн
тогтолцооны баталгаажуулалтыг
шилжүүлэх нь**

Энэхүү баримт бичиг нь ISO/IEC 17021-1:2015 стандартын 9.1.3-ыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. ISO/IEC 17021-1:2015 стандартын бүх заалтууд хүчинтэй хэвээр бөгөөд энэхүү баримт бичиг нь тухайн стандартад заасан шаардлагуудын аль нэгийг орлохгүй.

0. УДИРТГАЛ

Энэхүү баримт бичигт баталгаажуулалтын байгууллагуудын хооронд итгэмжлэгдсэн менежментийн тогтолцооны гэрчилгээг шилжүүлэх норматив шалгуурыг тусгасан болно. Тус шалгуурыг ОУИФ болон бүс нутгийн Олон талт хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагуудын нэгдэлд мөн хэрэглэж болно.

Энэхүү баримт бичгийн зорилго нь нэг баталгаажуулалтын байгууллагаас олгосон итгэмжлэгдсэн менежментийн тогтолцооны гэрчилгээг ижил төрлийн өөр байгууллагад шилжүүлсэн тохиолдолд түүний бүрэн бүтэн байдлыг хангахад оршино.

Энэхүү баримт бичигт итгэмжлэгдсэн гэрчилгээг шилжүүлэх хамгийн бага шалгуурыг тусгасан болно. Баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгч байгууллагын баталгаажуулалтын байгууллагыг сонгох эрх чөлөөг үндэслэлгүй буюу шударга бусаар хязгаарлаагүй тохиолдолд энд дурдсанаас илүү хатуу журам, арга хэмжээг авч болно

**IAF Mandatory Document for the Transfer
of Accredited Certification of Management
Systems**

This document is mandatory for the consistent application of Clause 9.1.3 of ISO/IEC 17021-1:2015. All clauses of ISO/IEC 17021-1:2015 continue to apply and this document does not supersede any of the requirements in that standard.

0. INTRODUCTION

This document provides normative criteria on the transfer of accredited management system certification between certification bodies. The criteria may also be applicable in the case of acquisitions of certification bodies accredited by an IAF or Regional MLA signatory.

The objective of this document is to assure the maintenance of the integrity of accredited management system certification issued by one certification body if subsequently transferred to another such body.

This document provides minimum criteria for the transfer of accredited certification. Certification bodies may implement procedures or actions which are more stringent than those contained herein provided that a client organization's freedom to choose a certification body is not unduly or unfairly constrained.

1. ХАМРАХ ХҮРЭЭ

1.1 Баталгаажуулалтыг шилжүүлэх нь

Баталгаажуулалтын шилжүүлэх гэдэг нь нэг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага (цаашид “Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага” гэх) өөр итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага (цаашид “Олгогч баталгаажуулалтын байгууллага” гэх)-аас олгосон хүчин төгөлдөр менежментийн тогтолцооны гэрчилгээг өөрийн гэрчилгээ болгон хүлээн зөвшөөрөхийг хэлнэ.

Олон тооны баталгаажуулалт (нэгээс дээш баталгаажуулалтын байгууллагын зэрэгцсэн баталгаажуулалт)-д дээрх тодорхойлолт хамаарахгүй бөгөөд ОУИФ-аас дэмждэггүй.

2. ХАМГИЙН БАГА ШААРДЛАГА

2.1 Баталгаажуулалтыг шилжүүлэхэд тавих нөхцөл

2.1.1 Зөвхөн ОУИФ эсхүл бүс нутгийн ХХЗХ-т нэгдсэн итгэмжлэлд хамрагдсан 3-р түвшний баталгаажуулалт, шаардлагатай тохиолдолд 4 болон 5-р түвшний баталгаажуулалтыг шилжүүлэх боломжтой. Ийм төрлийн итгэмжлэлд хамрагдаагүй баталгаажуулалттай байгууллагыг шинэ үйлчлүүлэгч гэж авч үзнэ.

2.1.2 Зөвхөн хүчин төгөлдөр итгэмжлэгдсэн баталгаажуулалтыг шилжүүлнэ. Түдгэлзүүлсэн баталгаажуулалтыг шилжүүлэхийг зөвшөөрөхгүй.

2.1.3 Баталгаажуулалтыг үйл ажиллагаагаа зогсоосон, итгэмжлэлийг нь түдгэлзүүлсэн, цуцалсан, хугацаа нь дууссан баталгаажуулалтын байгууллагаас олгосон тохиолдолд шилжүүлийг 6 сарын дотор эсхүл гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө хийнэ. Ийм тохиолдолд хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлэлийнхээ дагуу баталгаажуулалт олгохоор төлөвлөж буйгаа шилжүүлж авахаас өмнө итгэмжлэлийн байгууллагад мэдэгдэнэ.

1. DEFINITION

1.1 Transfer of Certification

The transfer of certification is defined as the recognition of an existing and valid management system certification, granted by one accredited certification body, (hereinafter referred to as the “issuing certification body”), by another accredited certification body, (hereinafter referred to as the “accepting certification body”) for the purpose of issuing its own certification.

Multiple certification (concurrent certification by more than one certification body) does not fall under the definition above, and is not encouraged by IAF.

2. MINIMUM REQUIREMENTS

2.1 Eligibility of a Certification for Transfer

2.1.1 Only certification which is covered by an accreditation of an IAF or Regional MLA signatory at level 3 and where applicable level 4 and 5 shall be eligible for transfer. Organizations holding certification that is not covered by such accreditations shall be treated as new clients.

2.1.2 Only valid accredited certification shall be transferred. Certification which is known to be suspended shall not be accepted for transfer.

2.1.3 In cases where certification has been granted by a certification body which has ceased trading or whose accreditation has expired, been suspended or withdrawn, the transfer shall be completed within 6 months or on expiration of the certification whichever is sooner. In such cases, the accepting certification body shall inform the accreditation body, under whose accreditation it intends to issue the certification, prior to the transfer.

2.2 Шилжүүлэхээс өмнөх дүн шинжилгээ

2.2.1 Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгчид үйл явцын талаар мэдээлэх, баталгаажуулалтын талаар шийдвэр гаргахын тулд хангалттай мэдээлэл авах үйл явцтай байна. Энэхүү мэдээлэл нь хамгийн багадаа баталгаажуулалтын мөчлөгтэй холбоотой зохицуулалтыг агуулсан байна.

2.2.2 Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь (шилжиж буй) үйлчлүүлэгчийн баталгаажуулалтад дүн шинжилгээ хийнэ.

Энэхүү дүн шинжилгээнд баримт бичгийн хяналт багтах бөгөөд шаардлагатай гэж үзвэл, жишээлбэл томоохон үл тохирол байгаа тохиолдолд баталгаажуулалтын хүчинтэй эсэхийг батлах зорилгоор хийгдэх шилжүүлэхээс өмнөх айлчлал зэрэг багтаана.

Тайлбар: Шилжүүлэхээс өмнөх айлчлал нь аудит биш юм.

2.2.3 Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь шилжүүлэхийн өмнөх дүн шинжилгээнд оролцох ажилтны чадамжийн шалгуурыг тогтооно. Дүн шинжилгээг нэг буюу хэд хэдэн хүн хийж болно. Шилжүүлэхээс өмнөх айлчлал хийж буй хувь хүн эсвэл бүлэг нь баталгаажуулалтын хамрах хүрээнд тохирсон аудитын багтай дүйцэхүйц ижил чадамжтай байна.

2.2.4 Дүн шинжилгээнд дор хаяж дараах асуудлуудыг хамруулах бөгөөд дүн шинжилгээ, түүний дүгнэлт бүрийг бүрэн баримтжуулсан байна. Үүнд:

- (i) Үйлчлүүлэгчийн баталгаажуулалт нь олгогч болон хүлээн авагч баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэгдсэн хамрах хүрээнд багтсан болох баталгаа;
- (ii) Шилжүүлж буй баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэгдсэн хүрээ нь ХХЗХ-т нэгдсэн итгэмжлэлийн байгууллагын хамрах хүрээнд багтсан болох баталгаа;

2.2 Pre-Transfer Review

2.2.1 The accepting certification body shall have a process for obtaining sufficient information in order to take a decision on certification and inform the transferring client of the process. This information shall as a minimum include arrangements regarding the certification cycle.

2.2.2 The accepting certification body shall carry out a review of the certification of the transferring client. This review shall be conducted by means of a documentation review and where identified as needed by this review, for example there are outstanding major nonconformities, shall include a pre-transfer visit to the transferring client to confirm the validity of the certification.

Note: The pre-transfer visit is not an audit.

2.2.3 The accepting certification body shall determine the competence criteria for personnel involved in pre-transfer review. The review may be conducted by one or more persons. The individual or group conducting the pre-transfer visit shall have the same competence that is required for an audit team appropriate for the scope of certification being reviewed.

2.2.4 The review shall cover the following aspects as a minimum and the review and its findings shall be fully documented:

- (i) confirmation that the client's certification falls within the accredited scope of the issuing and accepting certification body;
- (ii) confirmation that the issuing certification body's accredited scope falls within its accreditation body's MLA scope;
- (iii) the reasons for seeking a transfer;

- (iii) шилжүүлэх хүсэлт гаргах болсон шалтгаан;
- (iv) байршил эсхүл шилжүүлэх хүсэлт гаргаж буй хүчин төгөлдөр итгэмжлэгдсэн баталгаажуулалт бүхий байршил;
- (v) анхдагч баталгаажуулалт эсхүл хамгийн сүүлийн давтан баталгаажуулалтын аудитын тайлан, сүүлийн магадлан хяналтын тайлан; тэдгээрээс үүдэн гарч болзошгүй үл тохирлын байдал болон баталгаажуулалтын үйл явцтай холбоотой бусад боломжит, холбогдох баримт бичиг. Хэрэв эдгээр аудитын тайлангуудыг олж авах боломжгүй, эсвэл олгогч баталгаажуулалтын байгууллагын аудитын хөтөлбөрийн дагуу магадлан хяналт, давтан баталгаажуулалтын аудит хийгдээгүй бол тухайн байгууллагыг шинэ үйлчлүүлэгч гэж авч үзнэ;
- (vi) хүлээн авсан гомдол болон авсан арга хэмжээ;
- (vii) аудитын хөтөлбөр болон аудитын төлөвлөө гаргахтай холбоотой анхаарах зүйлс. Боломжтой бол олгогч баталгаажуулалтын байгууллагаас гаргасан аудитын хөтөлбөрийг хянан үзнэ. Тус баримт бичгийн 2.3.4 дэх заалтыг үзнэ үү.
- (viii) Баталгаажуулалтын хамрах хүрээтэй холбоотой үйлчлүүлэгчээс хуулийн нийцлийн дагуу зохицуулагч байгууллагатай хийсэн аливаа (одоогийн) тохиролцоо.

2.3 Баталгаажуулалтыг шилжүүлэх нь

2.3.1 ISO/IEC 17021-1:2015 стандартын 9.5.2-д заасны дагуу хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь шилжиж буй үйлчлүүлэгчид дараах нөхцлүүдийг хангах хүртэл баталгаажуулалтыг олгохгүй. Үүнд:

- (i) бүх хаагдаагүй том үл тохиролтой холбоотой залруулга болон залруулах арга хэмжээний хэрэгжилтийг нотолсон; болон

- (iv) that the site or sites wishing to transfer certification hold a valid accredited certification;
- (v) the initial certification or most recent recertification audit reports, and the latest surveillance report; the status of all outstanding nonconformities that may arise from them and any other available, relevant documentation regarding the certification process. If these audit reports are not made available or if the surveillance audit or recertification audit has not been completed as required by the issuing certification body's audit programme, then the organisation shall be treated as a new client;
- (vi) complaints received and action taken;
- (vii) considerations relevant to establishing an audit plan and an audit programme. The audit programme established by the issuing certification body should be reviewed if available. See Clause 2.3.4 of this document; and
- (viii) any current engagement by the transferring client with regulatory bodies relevant to the scope of the certification in respect of legal compliance.

2.3 Transfer of Certification

2.3.1 In accordance with clause 9.5.2 of ISO/IEC 17021-1:2015, the accepting certification body shall not issue certification to the transferring client until:

- (i) it has verified the implementation of corrections and corrective actions in respect of all outstanding major nonconformities; and

(ii) бүх хаагдаагүй жижиг үл тохирлын залруулга, залруулах арга хэмжээний талаарх үйлчлүүлэгчийн төлөвлөгөөг хүлээн авсан.

2.3.2 Шилжүүлэхээс өмнөх дүн шинжилгээ (баримт бичгийн хяналт ба/эсхүл шилжүүлэхээс өмнөх айлчлал)-ээр шилжүүлэлтийг дуусгахад саад болж буй асуудлыг тодорхойлсон тохиолдолд хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага шилжиж буй үйлчлүүлэгчийг шинэ үйлчлүүлэгч гэж авч үзнэ.

Энэ үйлдлийн үндэслэлийн талаар шилжиж буй үйлчлүүлэгчид тайлбарлах ба хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь бүртгэл хөтөлж, баримтжуулна.

2.3.3 Баталгаажуулалтын шийдвэр гаргахдаа ISO/IEC 17021-1:2015 стандартын 9.5-д заасны дагуу ердийн үйл явцыг дагах бөгөөд баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтнууд нь шилжүүлэхээс өмнөх дүн шинжилгээ хийж буй хүмүүсээс ялгаатай байна.

2.3.4 Шилжүүлэхээс өмнөх дүн шинжилгээгээр ямар нэгэн асуудал илрээгүй бол баталгаажуулалтын мөчлөгийг өмнөх баталгаажуулалтын мөчлөгт үндэслэх ба хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын мөчлөгийн үлдсэн хугацаанд аудитын хөтөлбөрийг тогтооно.

ТАЙЛБАР: Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын баримт бичигт тухайн байгууллагыг тодорхой хугацаанаас өмнө өөр баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан болохыг харуулсан анхдагч баталгаажуулалтын огноог иш татаж болно.

Шилжүүлэхээс өмнөх дүн шинжилгээний үр дүнд хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага үйлчлүүлэгчийг шинэ үйлчлүүлэгч гэж үзэх бол баталгаажуулалтын мөчлөг нь баталгаажуулалтын шийдвэрээс эхэлнэ.

(ii) it has accepted the transferring client's plans for correction and corrective action for all outstanding minor nonconformities.

2.3.2 Where the pre-transfer review (document review and/or pre-transfer visit) identifies issues that prevent the completion of transfer, the accepting certification body shall treat the transferring client as a new client.

The justification for this action shall be explained to the transferring client and shall be documented by the accepting certification body and the records maintained.

2.3.3 The normal certification decision making process in accordance with clause 9.5 of ISO/IEC 17021-1:2015 shall be followed including that the personnel making the certification decision be different from those carrying out the pre-transfer review.

2.3.4 If no problems are identified by the pre-transfer review, the certification cycle shall be based on the previous certification cycle and the accepting certification body shall establish the audit programme for the remainder of the certification cycle.

NOTE: The accepting certification body can quote the organization's initial certification date on the certification documents with the indication that the organization was certified by a different certification body before a certain date.

Where the accepting certification body has had to treat the client as a new client as a result of the pre-transfer review, the certification cycle shall begin with the certification decision.

2.3.5 Баталгаажуулалтын тухай шийдвэрийг хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага магадлан шалгалт, давтан баталгаажуулалт эхлэхээс өмнө гаргана.

2.4 Баталгаажуулалтыг Олгогч болон Хүлээн авагч байгууллага хоорондын хамтын ажиллагаа

2.4.1 Баталгаажуулалтыг шилжүүлэх үйл явцыг үр дүнтэй байлгах, баталгаажуулалтын бүрэн бүтэн байдлыг хангахад баталгаажуулалтыг олгогч болон хүлээн авагч байгууллагуудын хамтын ажиллагаа чухал юм. Баталгаажуулалтыг олгогч байгууллага нь хүсэлт гаргасан тохиолдолд баталгаажуулалтын хүлээн авагч байгууллагыг бүх шаардлагатай баримт бичиг, мэдээллээр хангана. Баталгаажуулалтыг олгогч байгууллагатай харилцах боломжгүй бол баталгаажуулалтын хүлээн авагч байгууллага нь шалтгааныг тэмдэглэж, шаардлагатай мэдээллийг бусад эх сурвалжаас авахын тулд бүх хүчин чармайлтаа гаргана.

2.4.2 Шилжиж буй үйлчлүүлэгч нь хүлээн авагч баталгаажуулалтын байгууллагыг хүссэн мэдээллээр хангахыг баталгаажуулалт олгогч байгууллагад зөвшөөрнө. Хэрэв үйлчлүүлэгч баталгаажуулалтын шаардлагад үргэлжлэн нийцэж байгаа бол баталгаажуулалт олгогч байгууллага нь шилжүүлж буй мэдэгдлийн дараа тухайн үйлчлүүлэгчийн баталгаажуулалтыг түдгэлзүүлэх эсхүл цуцлахгүй.

2.4.3 Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага болон/эсхүл шилжиж буй үйлчлүүлэгч нь баталгаажуулалт олгогч байгууллагыг итгэмжилсэн итгэмжлэлийн байгууллагатай дараах асуудлаар холбогдоно. Үүнд:

- (i) Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллагыг хүссэн мэдээллээр хангаагүй, эсхүл

2.3.5 The accepting certification body shall take the decision on certification before any surveillance or recertification audits are initiated.

2.4 Cooperation Between the Issuing and Accepting Certification Bodies

2.4.1 The cooperation between the issuing and accepting certification bodies is essential for the effective process for transfer and the integrity of certification. When requested, the issuing certification body shall provide to the accepting certification body all the documents and information required by this document. Where it has not been possible to communicate with the issuing certification body, the accepting certification body shall record the reasons and make every effort to obtain necessary information from other sources.

2.4.2 The transferring client shall authorise that the issuing certification body provides the information sought by the accepting certification body. The issuing certification body shall not suspend or withdraw the organization's certification following the notification that the organization is transferring to the accepting certification body if the client continues to satisfy the requirements of certification.

2.4.3 The accepting certification body and/or the transferring client shall contact the accreditation body which accredits the issuing certification body where the issuing certification body

- (i) has not provided the requested information to the accepting certification body, or
- (ii) suspends or withdraws the transferring client's certification without cause

(ii) Шилжиж буй үйлчлүүлэгчийн баталгаажуулалтыг шалтгаангүйгээр түдгэлзүүлсэн эсхүл цуцалсан.

2.4.4 Итгэмжлэлийн байгууллага нь баталгаажуулалт олгогч байгууллага хүлээн авагч байгууллагатай хамтран ажиллаагүй эсхүл шилжиж буй үйлчлүүлэгчийн баталгаажуулалтыг шалтгаангүйгээр түдгэлзүүлсэн буюу цуцалсан тохиолдолд итгэмжлэлийг түдгэлзүүлэх эсхүл цуцлах зэргийг багтаасан нөхцөл байдлыг шийдвэрлэх үйл явцтай байна.

2.4.5 Хүлээн авагч баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалт олгосны дараа энэ тухай баталгаажуулалтыг олгогч байгуулагад мэдэгдэнэ.

Итгэмжлэгдсэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг шилжүүлэх ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийн төгсгөл

2.4.4 The accreditation body shall have a process for addressing the situation, including the suspension or withdrawal of the accreditation, where the issuing certification body does not cooperate with the accepting certification body or suspends or withdraws the transferring client's certification without cause.

2.4.5 Once the accepting CB has issued the certification it shall inform the issuing CB.

End of IAF Mandatory Document for the Transfer of Accredited Certification of Management Systems.

Нэмэлт мэдээлэл:

Тус баримт бичиг болон ОУИФ-ын бусад баримт бичгийн талаарх нэмэлт мэдээллийг ОУИФ-ын гишүүн, нарийн бичгийн дарга нарын газартай холбогдоно уу.

ОУИФ-ын гишүүдийн талаарх мэдээллийг <http://www.iaf.nu>. цахим хуудаснаас авна уу.

Нарийн бичгийн дарга нарын газар:

ОУИФ-ын нарийн бичгийн дарга
Утас: +1 613 454-8159
И-мейл: secretary@iaf.nu

Further Information:

For further Information on this document or other IAF documents, contact any member of IAF or the IAF Secretariat.

For contact details of members of IAF see the IAF website <http://www.iaf.nu>.

Secretariat:

IAF Corporate Secretary
Telephone: +1 613 454-8159
Email: secretary@iaf.nu